

**БАТЛАВ.**  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ **Д.МӨНХБАЯР**

## **БАТАЛГААЖСАН ҮҮЛДЭР, ОМГИЙН БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

### **1.Зорилго.**

Баталгаажсан үүлдэр, омгийн малын цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгчээр хангах замаар бог малын чанарыг богино хугацаанд сайжруулах ажлыг зохион байгуулахад энэхүү ажлын зорилго оршино.

### **2.Нийтлэг үндэслэл.**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/71 дүгээр тушаал “Үзлэг ангилалтын заавар батлах тухай”, 2019 оны А/114 дугаар тушаал “Малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тайлагнах журам”, 2020 оны А/336 дугаар тушаал “Сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх технологийн журам”, 2022 оны А/ 144 дүгээр тушаал “Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох тухай журам”, 2024 оны А/137 дугаар тушаал “Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, нийлүүлэх хуваарь батлах тухай” удирдамжийн дагуу бог малын хээлтүүлэгчийг нийлүүлэх, ялган төвлөрүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулна.

### **3. Оролцогчид тавигдах шаардлага.**

- 3.1 Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, хоршоо, нөхөрлөл, хуулийн этгээд байх
- 3.2 Малын үзлэг ангилалт, бүртгэлийг ажлыг зохион байгуулдаг байх
- 3.3 Үржлийн бүртгэлийг тогтмол хөтөлж, хариуцсан сумын үржлийн ажлыг удирдан зохион байгуулахад хамтран ажилласан байх
- 3.4 Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлснээр гарах үр дүнгийн талаарх танилцуулга, мэдээлэл сургалтыг малчдад хүргэх ажлыг зохион байгуулсан байх

### **4. Бог малын хээлтүүлэгчид тавигдах шаардлага.**

- 4.1 Мал шинжээч мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын үзлэг ангилалтад жил бүр хамрагдсан, үржлийн анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлсөн байх
- 4.2 Мэргэжлийн байгууллагаар малын удам гарваль, ашиг шимийн гарц чанарыг тогтоолгож баталгаажуулсан гэрчилгээтэй байх
- 4.3 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол хамрагдсан, эрүүл болох нь мэргэжлийн байгууллагаар дүгнэгдсэн байх
- 4.4 Цөм сүргийн хээлтүүлэгчийн ашиг шимийн дундаж үзүүлэлт нь тухайн үүлдэр, омгийн малын шилмэл ангийн шаардлагыг хангасан байх
- 4.5 Малыг үл давтагдах хувийн дугаараар ялган тэмдэглэж, малын нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн байх
- 4.6 “Мах-өөх-бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонины цөм сүргийн босго үзүүлэлтийг хангасан байх

**“Мах-өөх-бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд:**

д/д	Нас, хүйсийн ялгаа	Амьдын жин, кг		Ноосны гарц кг	Товч тайлбар
		Хаврын	Намрын		
<b>Барга үүлдрийн хонь:</b>					
1	Төлгөн хуц	32	46	1,0	Барга үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Барга үүлдрийн хонь нь мах-өөхний хэв шинж сайн тодорсон, улаан толгойтой, шар халзан зүстэй, сүүл ууц нуруундаа харьцангуй их хэмжээний өөх хуримтлуулсан, бага зэрэг өргөгдсөн богино зузаан отгогүй мухар өөхөн сүүлтэй, галбирын согоггүй, эрүүл чийрэг хонь байна.
<b>Буриад омгийн хонь:</b>					
2	Төлгөн хуц	35	52	1,2	Буриад үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Буриад омгийн хонь нь цээж өргөн, гүн, ууц ялимгүй өргөгдсөн, харьцангуй богино зузаан өөхөн сүүлтэй, улаан, шар, бор толгойтой, их бие нь хундан цагаан зүстэй, туг хэлбэрийн бүдүүн ноостой, эрүүл чийрэг хонь байна.

**5. Худалдан авах ажиллагааны хуваарь**

д/д	Үүлдэр, омог	Нас	Худалдан авах хээлтүүлэгч	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт санхүүжилт мян.төг/
			Тоо, толгой		
1	Барга үүлдрийн хуц	2	40	380,375	15,215,000
2	Буриад омгийн хуц	2	40	380,375	15,215,000
<b>Нийт дүн</b>			<b>80</b>		<b>30,430,000</b>


**6. Бог малын хээлтүүлэгч нийлүүлэх нийт зардлын тооцоо**

№	Үйл ажиллагааны нэр	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бог малын хээлтүүлэгч худалдаж авах	80	380,375	30,430,000
2	Хяналтын зардал	3	93,500	1,570,000
<b>Нийт зардал</b>		<b>83</b>	<b>473,875</b>	<b>32,000,000</b>

ХЯНАСАН:

МАЛ ҮРЖЛИЙН АЛБАНЫ  
ДАРГА  Д.НАРАНХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН БҮРТГЭЛ,  
МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, ЯЛГАН ТЭМДЭГЛЭГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Б.ОЮУНТУЯА